

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж ажиллана. Үүнд:

3.1.Шударга хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлж, аймгийнхаа төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмж, шуурхай байдлыг шинэ шатанд гаргах.

3.2.Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, манлайлал, ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг сайжруулах.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1. Нэгдүгээр зорилтын хүрээнд:

4.1.1.Иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдолд хуулийн хугацаанд тодорхой хариу өгч, үйлчилгээний найрсаг, эерэг хандлагыг бий болгоно.

4.1.2.Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид иргэний үүргийнхээ дагуу Багийн иргэдийн нийтийн хуралд биечлэн оролцож, иргэдийн санал хүсэлтийг сонсож, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ.

4.1.3.Төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, иргэд, иргэний нийгмийн байгууллага, бизнес эрхлэгчдэд чанартай, соёлтой, хүртээмжтэй, хүнд сурталгүй, авлигагүй үйлчилгээ үзүүлэх зорилтыг бүх талаар хангаж ажиллана.

4.1.4.Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй хүргэх зорилгоор цахим мэдээлэл, олон нийтийн сүлжээ зэрэг техник, технологийн дэвшилтэт ололтуудыг нэвтрүүлэх замаар Тунгалаг төр, шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.

4.1.5.Цагийн менежментийг чанд мөрдөж, хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, хэлэлцүүлгийг товлосон цагт нь эхлүүлж хэвшинэ.

4.1.6.“Хариуцлагатай-Тунгалаг төр” мэдээллийн цаг ажиллуулж, иргэд, олон нийтэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тогтмол мэдээлж, байгууллага бүр 7 хоногийн ажлын эхний өдөр сонсгол мэдээллийг тогтмол хийж байна.

4.1.7.Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, сумдын Засаг даргын Тамгын газар зэрэг байгууллагуудад “Хөтөч” үйлчилгээг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан нэвтрүүлнэ.

4.1.8.Тэргүүний сум, байгууллага шалгаруулах арга хэмжээний үндсэн үзүүлэлт нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн байх бөгөөд жил бүр жишиг сум, байгууллага, төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж шагнаж, урамшуулна.

4.1.9.Төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, төрийн үйлчилгээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, нийгмийн эгэх хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.10.Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ үрэлгэн зардлыг багасгаж, төсөв санхүүгийн хэмнэлттэй бодлогыг баримталж, төсвийг үр ашгийг дээшлүүлж хэмнэсэн зардлаараа албан хаагчдаа чадавхжуулна.

4.1.11.Төрийн үйлчилгээний хүнд суртал, алдаа дутагдал гаргаж, ажилд нь өөрчлөлт дэвшил гарахгүй байгаа албан байгууллага болон түүний удирдлага, ажилтан, албан хаагчдын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль дүрэм, журмын дагуу хариуцлага тооцож ажлыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд:

4.2.1.Төрийн албан хаагчдын манлайлал, ёс зүй, соёл, харилцаа, хандлагыг дээшлүүлэх чиглэлд танхимын сургалтуудыг зохион байгуулна.

4.2.2.Төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх ажлын байрны дэг журмыг чанд сахих талаар ажлын байранд нь дадлагажуулах арга зүйн сургалтуудыг тогтмолжуулна.

4.2.3.Төрийн албан хаагч бүрийн сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим болон бусад холбогдох хууль, тогтоомжуудыг сурталчлах, өдөр тутмын үйл ажиллагаандаа чанд мөрдөх зан үйлд сургана.

4.2.4.Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тухайн албан хаагчийн манлайлал, харилцаа, хандлага, ёс зүй, үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангах тухай тодорхой тусгаж, гэрээг дүгнэх үзүүлэлт болгож хэвшинэ.

4.2.5.Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлж, чадавхжуулах танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

4.2.6.Төрийн албан хаагчдыг ажил үүргийн чиглэлийн дагуу гадаад, дотоодын сургалт семинар, зөвлөгөөн, туршлага судлах арга хэмжээнүүдэд хамруулж, чадавхиж, мэргэших нөхцөлөөр хангана.

4.2.7.Төрийн албан хаагчдын дунд мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн зорилтот арга хэмжээг зохион байгуулна.

4.2.8.Аймгийн Засаг даргын Тамгын газрын сургалт зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, сургалтын мэргэшсэн багтай болно.

Тав. Төрийн албан хаагчийн баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээ

5.1 Албан хаагч үүргээ мэргэжлийн өндөр түвшинд шударгаар гүйцэтгэх зарчим баримтална.

5.2 Төрийн албан байгууллагуудаас гаргаж байгаа аливаа шийдвэр, үйлчилгээ нь хуульд нийцсэн байна.

5.3 Иргэдээс аливаа зүйлийг нууж дарагдуулан шийдвэр гаргахгүй, аливаа байдлаар саад учруулж, цаг алдагдуулахыг цээрлэнэ.

5.4 Албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ хэнийг ч ялгаварлаж хандахгүй байхын зэрэгцээ, хамт ажиллаж байгаа болон бусад хүмүүсийн эрхийг хүндэтгэх, төр засгаас хүлээлгэсэн итгэлийг дааж ажиллах зарчим баримтална.

5.5.Төрийн албаны удирдах ажилтны Улсын зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмж, Андгайг бүх шатны төрийн албан хаагчид мөрдөж ажиллана.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт, удирдлага зохион байгуулалт.

Хөтөлбөрийг 2018-2021 онуудад хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

- Улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан
- Хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж хандив,
- Төрийн болон төрийн бус байгууллагын санаачилгаар хуримталсан хөрөнгө,
- Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө,
- Бусад эх үүсвэр

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 3 жилийн хугацаанд нийт 150,0 сая төгрөг, жилд дунджаар 50,0-60,0 сая төгрөг шаардагдана.

Хөтөлбөрийн санхүүжилт үйл ажиллагаа тус бүрээр

Д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Санхүүжилт /сая. төг/			Нийт санхүүжилт
		2019	2020	2021	
1	Төрийн албан хаагчдын манлайлал, ёс зүй, соёл, харилцаа, хандлагыг дээшлүүлэх чиглэлд танхимын сургалтууд зохион байгуулах	10,0	10,0	5,0	25,0
2	Төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх ажлын байрны дэг журмыг чанд сахих талаар талаар ажлын байранд нь дадлагажуулах арга зүйн сургалтууд зохион байгуулах	2,0	2,0	1,0	5,0

3	Төрийн албан хаагч бүрийн сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх чиглэлд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим болон бусад холбогдох хууль, тогтоомжуудыг сурталчлах, өдөр тутмын үйл ажиллагаандаа чанд мөрдөх зан үйлд сургах	2,0	2,0	1,0	5,0
4	Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тухайн албан хаагчийн манлайлал, харилцаа, хандлага, ёс зүй, үйл ажиллагааны ил тод байдлыг хэрхэн хангах тухай тодорхой тусгаж, гэрээг дүгнэх үзүүлэлт болгож хэвших	-	-	-	-
5	Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлж, чадавхжуулах танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлэх	5,0	5,0	2,0	12,0
6	Төрийн албан хаагчдыг ажил үүргийн чиглэлийн дагуу гадаад, дотоодын сургалт семинар, зөвлөгөөн, туршлага судлах арга хэмжээнүүдэд хамруулж, чадавхжиж, мэргэшэх нөхцөлөөр хангах	10,0	5,0	3,0	18,0
7	Төрийн албан хаагчдын дунд мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн зорилтот арга хэмжээг зохион байгуулах	2,0	2,0	1,0	5,0
8	Аймгийн ЗДТГ-ын сургалт зохион байгуулах чадавхыг бэхжүүлэх	3,0	1,0	1,0	5,0
9	НИЙТ	34,0	27,0	14,0	75,0

Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлагаар хангах, зохицуулах, санхүүжилтийн эрх гаргуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн Захиргааны удирдлагын хэлтэс нь хөтөлбөрийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, биелэлтийг тооцох үүргийг хүлээнэ.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн,

7.1. Шударга хариуцлагатай, ил тод нийтийн алба бэхжиж, төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмж, шуурхай байдлыг шинэ шатанд гаргасан байна.

7.2. Үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн байгууллага, хамт олон, албан хаагчдын сахилга, хариуцлага сайжирсан байна.

7.3.Төрийн үйлчилгээний албан хаагчдын харилцааны соёл, харилцаа, хандлага, хариуцлага, ёс зүйтэй холбоотой иргэд, олон нийтийн гомдол, мэдээлэл буурсан байна.

7.4.Төрийн үйлчилгээний ил тод байдал эрс нэмэгдэж, шилэн дансны хууль тогтоомж хэрэгжсэн байна.

7.5.Төр, иргэний нийгмийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо эрс сайжирч, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлсэн төрийн ажил үйлчилгээний тоо нэмэгдсэн байна.

7.6.Төсөв, санхүүгийн хэмнэлттэй бодлого хэрэгжиж, төсвийн үр ашиг дээшилж, хэмнэсэн зардал, мөнгөөр албан хаагчдыг чадваржуулах чиглэлд зохион байгуулсан ажлын үр дүн дээшилсэн байна.

7.7.Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, хэлэлцүүлэг зэрэг аливаа арга хэмжээ цагтаа эхэлдэг болж, цаг ашиглалт сайжирсан байна.

7.8.Төрийн байгууллага, албан хаагчдын ёс зүй, соёл, харилцаа хандлага, хариуцлага дээшилж, төрд итгэх иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.

7.9.Төрийн ажил үйлчилгээ нь шударга шуурхай болж, хүнд сурталгүй, авлигагүй болсон байна.

7.10.Төрийн албан хаагчдыг сургалтад хамруулах замаар мэдлэг боловсролыг нь дээшлүүлснээр чадварлаг, мэргэшсэн хүний нөөц бүрдсэн байна.

Найм. Шалгуур үзүүлэлт.

Д/Д	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		
		Суурь түвшин	Хүрэх түвшин /оноор/	Түвшин
		2018 он	2019 он	2020 он
1	Төрийн байгууллага, албан хаагчдын ёс зүй, соёл, харилцаа хандлагын талаарх иргэдийн сэтгэл ханамж /хувиар/	73	75	80-аас дээш
2	Төрийн албан хаагчдын гаргасан ёс зүйн зөрчлийн тоо	18	12	00
3	Тогтоосон хугацаандаа эхэлсэн арга хэмжээний тоо /хувиар/	-	70	100
4	Хэмнэгдсэн төсөв /сая, төг/			
5	Хэмнэсэн зардал, мөнгөөр зохион байгуулсан албан хаагчдыг чадавхжуулах сургалтын тоо	-	5	5
6	Иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаар хийж гүйцэтгүүлсэн төрийн ажил үйлчилгээний тоо	1	3	5
7	Төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлд хийсэн ажлуудын тоо	-	10	10
8	Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилт /хувиар/	46	60	80
9	Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан гомдол мэдээлэл буурсан /хувь/	40	25	5-аас доош
10	"Хөтөч" үйлчилгээ нэвтрүүлсэн байгууллагын тоо	3	4	6
11	"Хариуцлагатай тунгалаг төр" мэдээллийн тоо	-	12	12
12	Төрийн үйлчилгээний нээлттэй, ил тод, хариуцлагатай байх үйл ажиллагаанд нэвтрүүлсэн техник, технологийн дэвшилтэт ололтуудын тоо	-	2	4-өөс дээш
13	Төрийн албан хаагчдын манлайлал, ёс зүй, соёл, харилцаа, хандлагыг дээшлүүлэх чиглэлд	2/12	10/40	16/60

	зохион байгуулсан танхимын сургалт /сургалтын тоо, цаг, хамрагдсан төрийн албан хаагчдын тоо/			
14	Төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тухайн албан хаагчийн манлайлал, харилцаа, хандлага, ёс зүй, соёл, үйл ажиллагааны ил тод байдлыг тусгаж, үнэлсэн байдал	00		
15	Гадаадад сургалт, семинар, зөвлөгөөн, туршлага судлах, танилцах аялалд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо	00	6	12
16	Ажил үүргийн чиглэлийн дагуу дотоодын сургалт, семинар, зөвлөгөөн, туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо	00	14	25
17	Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	1	6	18
18	Төрийн албан хаагчдын дунд мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх чиглэлд зохион байгуулсан төрөл бүрийн зорилтот арга хэмжээний тоо	1	5	5

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт үнэлгээ, түүний зохион байгуулалт

9.1 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтэд улирал бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг хагас бүтэн жилээр нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал танилцуулж, Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.

9.2 Байгууллага бүр хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, улирал бүрийн тайлангаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст ирүүлж хэвшинэ.

9.3 Байгууллага бүр иргэдийн дунд сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, дүнг нэгтгэн хэлэлцэж, тайландаа тусгадаг болно.

9.4 Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг тооцон, иргэдэд ил тод мэдээлж бүх төрийн байгууллага хамт олон харилцааны өндөр соёлтой, шуурхай, шударга ил тод байдлыг эрхэмлэн төрийн үйлчилгээний соёл, хүртээмж чанар сайтай, хүнд сурталгүй, авлигагүй аймаг болох нөхцөлийг бүрдүүлнэ.

9.5 Иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжид сэтгэл ханамжтай, бодлого зорилтыг дэмждэг зөв эерэг хандлага төлөвшинө.